



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны III байр
Утас: 7011-1284, Факс: (976-11) 31-15-09
<http://www.ub.inspection.gov.mn>
E-mail: ub_info@inspection.gov.mn

2017.02.21 № 02-02/118
танай _____-ны № _____-т

БАТЛАВ
ДЭД ДАРГА Б БАТШАГАЙ



Шалгалт хийх тухай

Нэг. Шалгалтын зорилго, үндэслэл.

Сар шинийн баярын үед болзошгүй хордлого, халдвараас урьдчилан сэргийлэх бэлэн байдал хэрхэн хангагдсан байдлыг шалгаж, үнэлэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвөлгөө өгөхөд шалгалтын зорилго оршино.

Хоёр. Шалгалтын төрөл, арга хэлбэр.

Төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт.

Гурав. Шалгалтын хүрээ, шалгалтанд хамрагдах аж ахуйн нэгж, байгууллага, иргэн обектын нэр.

Шалгалтад Гэмтэл Согог судлалын үндэсний төв, Нийслэлийн түргэн тусламжийн төв, Өргөө, Хүрээ, Амгалан амаржих газрууд, Хордлогын төв, Баянгол, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй, Баянзүрх, Налайх, Багануур дүүргүүдийн Эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгүүд, Нийт 18 эрүүл мэндийн байгууллага хамрагдана.

Дөрөв. Шалгалтын бүрэлдэхүүн

Шалгалтыг Эмчилгээний чанарын хяналтын улсын ахлах байцаагч Б. Байгальмаа, Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч С.Отгонжаргал, Эм биобэлдмэлийн хяналтын улсын ахлах байцаагч Т.Чанцалдулам нар ахалж, дүүргүүд дэх Мэргэжлийн хяналтын Эмчилгээний чанарын хяналтын, Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын, эм биобэлдмэлийн хяналтын улсын /ахлах/ байцаагчид хамтран гүйцэтгэнэ.

/Шалгалт хийх улсын байцаагчид, сар шинийн өдрүүдэд ажиллах ажлын хэсгийн хуваарийг хавсаргав./

Тав. Шалгалт эхлэх болон дуусах хугацаа.

2017 оны 2 дугаар сарын 23 -24, 2 дугаар сарын 28-ны өдрүүдэд хийж гүйцэтгэнэ.

Зургаа. Өмнө хийсэн шалгалтын талаархи мэдээлэл.

Сар шинийн баяртай холбоотой 2016 оны 01 дугаар сарын 05-12-ны өдрүүдэд НМХГ-ын газрын даргын баталсан "Шалгалт хийх тухай" 02-01/35 дугаартай удирдамжийн дагуу Батлан Хамгаалах Хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлэг, Гэмтэл Согог судлалын үндэсний төв, Номун, Ачтан, Нийслэлийн Түргэн

005050005970

тусламжийн төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв болон Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй, Баянгол, Баянзүрх дүүргүүдийн Эрүүл мэндийн төвүүд болон Хан-Уул, Чингэлтэй, Баянгол, Баянзүрх дүүргүүдийн Эрүүл мэндийн төвүүд болон Хан-Уул, Сонгинохайрхан, Баянзүрх, Сүхбаатар, дүүргийн Нэгдсэн эмнэлгүүдийн хүлээн авах яаралтай тусламжийн нэгжүүд, нийт 16 байгууллага хамрагдаж, эмнэлгүүдийн хүлээн авах, яаралтай тусламжийн нэгжийн үйл ажиллагааны бэлэн байдал хангалттай түвшинд байсан ба шалгалтанд хамрагдсан албан тушаалтнуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Долоо. Шалгалт хийх чиглэл, хамрах хүрээ.

Эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр:

7.1. Эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээний шуурхай байдал, хүлээн авах, яаралтай тусламжийн нэгжийн байнгын бэлэн байдал хангагдсан эсэх, сар шинийн баярын үед ажиллах эмч, эмнэлгийн ажилтнуудын хариуцлагатай жижүүр, дуудагдаж ажиллах хуваарь, зохион байгуулалтыг баярын үеэр хэрхэн ажиллах талаар гаргасан тушаал, шийдвэрийн байдал;

7.2. Баяр наадам, болзошгүй хордлого, халдварын үед ажиллах эмч, мэргэжилтэн, шаардлагатай эм хэрэгсэл, хоол хүнс, цахилгаан машин, шатахуун нөөцийг газар дээр нь бэлэн болгосон байдал;

Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр:

7.3. Болзошгүй хордлого, халдварын үед ажиллах төлөвлөгөө, дуудах схем, тэдгээрийн баталгаажилт, тодотгол хийсэн байдал;

7.4. Эмнэлгүүдийн тусгаарлах өрөөний халдварын эсрэг дэглэмийн хэрэгжилтийн байдал;

7.5. Болзошгүй хордлого, халдварын үед үйлчлүүлэгчдээс шинжлэгдэхүүн цуглуулахад шаардлагатай материал, хэрэгслийн хангалт, нөөц /ариутгасан шил, сав, ариун хуруу шил, арчдасны нэг удаагийн бамбар, зүү тариур г.м/ түүнийг хадгалах нөхцөл;

7.6. Халдваргүйжүүлэх бодисын нөөц, баталгаажилт хэрэглээ;

Эм биобэлдмэлийн чанарын хяналтын чиглэлээр:

7.7. Эмийн санд тавих нийтлэг шаардлага" MNS 5260:2015 стандарт 11.9, ЭМС-ын 2009 оны "Аминчухалэм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг зохицуулах тухай" 388 дугаар тушаалын 2.1, 2.2 дах "Зайлшгүй шаардлагатай эмээр тасалдалгүй хангахад хүрэлцэхүйц нөөцтэй, тасалдлын бүртгэлтэй, амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг ханган ажилладаг" эсэх;

7.8. ЭМС-ын 2005 оны "Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх үлгэрчилсэн журам батлах тухай" 297 дугаар тушаалын 2.4, 5.1 дах "Эмнэлгийн үйл ажиллагааны онцлогоос хамааран яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах эм, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангасан түүнийг зохистой зарцуулдаг" эсэх;

7.9. ЭМС-ын 2005 оны "Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх үлгэрчилсэн журам батлах тухай" 297 дугаар тушаал 2.3, 2.5, 5.1 дах "Холын болон алсын дуудлагаар үйлчлэхэд шаардагдах эм, багаж хэрэгслээр хангагдсан, байнгын бэлэн байдалд байдаг" эсэх;

7.10. Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэгдэж байгаа эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн нь Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, хэрэглэх хүчинтэй хугацаатай, чанарын баталгаатай эсэх;

7.11. Дээрх асуудлын хүрээнд шалгаж эмчилгээний чанарын хяналт, эрүүл ахуй, халдвар хамгаалал, эм биобэлдмэлийн хяналтын чиглэлээр холбогдох, үнэлгээ дүгнэлт өгч танилцуулга бичиж ирүүлэх;

Найм. Шалгалтын үр дүнг нэгтгэх, тайлагнах.

8.1. Хяналт шалгалт хийсэн дүнг файлаар болон цаасаар 2017 оны 03 дугаар сарын 2-ны өдөр Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын хэлтэст ирүүлэх ба шалгалтын дүнг нийслэлийн хэмжээнд нэгтгэж, 2016 оны 03 дугаар сарын 3-ны өдөр холбогдох удирдлагуудад танилцуулна.

8.2. Зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:

ЭМЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

Б.БАЙГАЛЬМАА

ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН
ХЯНАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

С.ОТГОНЖАРГАЛ

ЭМ,БИОБЭЛДМЭЛИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

Н.ЧАНЦАЛДУЛАМ